



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/03/СТА-ЗГТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Дорноговь аймаг Сайншанд сум  
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа  
Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn  
Аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг  
Утас: 70523020 Цахим хаяг:  
Аудитор: Ц.Энхтуяа  
Утас: 99042645 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	7
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар .....	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал .....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	12

---

## Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Л.ШАГДАРСҮРЭН ТАНАА

2020.02.28 № 1-6/149  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Л.Шагдарсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 02-ноос 2020 оны 02 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс аудит ХХК-ний аудитор Ц.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь даатгуулагчдад хөнгөн шуурхай, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх замаар нийгмийн даатгалын хүрээг өргөтгөх, тэтгэвэр, тэтгэмж авах, хуульд заасан бусад бусад бүрэн эрхээ эдлэх нөхцөлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын үйл ажиллагаа

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн нийгмийн даатгалын газрын санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судална, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 44 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 42,972,617.8 мянган төгрөгөөс тооцон 859,452.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 821,837.7 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,103,539.4	5,414,306.3	1,310,766.9
Авлага	1,606,593.5	1,167,847.8	(438,745.6)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	11,920.9	11,367.8	(553.1)
Үндсэн хөрөнгө	494,177.6	444,547.2	(49,630.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,216,231.4</b>	<b>7,038,069.1</b>	<b>821,837.7</b>
Өр төлбөр	303,094.0	428,091.7	124,997.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,913,137.3	6,609,977.4	696,840.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,216,231.4</b>	<b>7,038,069.1</b>	<b>821,837.7</b>

Авлага дансны үлдэгдэл 438,745.6 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бууруулах талаар зорилго тавин ажилласнаас шалтгаалсан байна. Мөн 5-аас дээш жилийн насжилттай 16,479.2 мянган төгрөгийн авлага байна. Бараа материал дансны үлдэгдэл 553.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 17,121.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 8,329.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, нийт 26,0004.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна. Үндсэн хөрөнгө данс 49,630.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,310,766.9 мянган төгрөгөөр, өр төлбөрийн данс бараа үйлчилгээний зардлаас шалтгаалан 124,997.7 мянган төгрөгөөр, Засгийн газрын оролцоо 696,840.0 мянган төгрөгөөр өссөн байна.

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь тайлант онд улсын төсвөөс 13,603,454.2 мянган төгрөгийн, Нийгмийн даатгалын сангаас 9,533,063.9 мянган төгрөгийн санхүүжилт тус тус батлагдсанаас гүйцэтгэлээр Нийгмийн даатгалын сангаас 35,441,372.2 мянган төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Улсын төсвөөс санхүүжих	13,603,454.2		(13,603,454.2)
Нийгмийн даатгалын сангаас	29,533,063.9	35,441,372.2	5,908,308.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос		39,641.8	39,641.8
Туслах үйл ажиллагааны орлогоос		391.9	391.9
<b>Нийт дүн</b>	<b>43,136,518.1</b>	<b>35,481,405.9</b>	<b>(7,655,112.2)</b>

Үндсэн үйл ажиллагааны орлогод алдангийн орлого 21,441.0 мянган төгрөгийн, актын төлбөрийн орлого 17,600.8 мянган төгрөг, торгуулийн орлого 600.0 мянган төгрөг, нийт 39,641.8 мянган төгрөгийн орлого тус тус багтсан байна.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2019 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 43,136,518.1 мянган төгрөгийг урсгал зардалд, зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 43,136,518.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын төлөвлөгөөг бодиттой үнэн зөв төлөвлөдөггүй алдаа байна.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 42,972,617.9 мянган төгрөг буюу 99.6 хувь, зардлын нийт гүйцэтгэл 42,972,617.9 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллаас 5.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 504.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 112.2 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардлыг 33.2 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 6.1 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 89.7 мянган төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээг 3,708.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,700.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалжээ.

**Нэмэлт санхүүжилт:** Дээд шатны төсвийн захирагчаас 3,681.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 1,100.0 мянган төгрөгийг тээвэр, шатахууны зардалд 325.0 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардалд, 400.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээтэй төлбөр хураамжийн зардалд, 1,856.0 мянган төгрөгийг ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд тус тус зарцуулсан байна.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,617,211.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,617,211.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 1,617,211.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

### **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 24,786.4 мянган төгрөгийн өглөгтэй гарсан зөрчилд зөвлөмж хүргүүлснийг 1 дүгээр сард багтаан барагдуулсан, Бараа материалын тайлан батлагдсан маягтын дагуу гаргаж хэвшсэн, ээлжийн амралтын тухай мэдэгдлийг батлагдсан маягтын дагуу хөтөлж өмнөх зөвлөмжийг биелүүлж ажилласан байна. Гэвч шинээр өр авлага дахин үүссэн байна.

Нийт 5 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж 80 хувьтай байна.

### **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## **Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. Балансын данстай холбоотой асуудал**

#### **1.1 Илрүүлэлт:**

Тус байгууллага тайлант хугацаанд нийт 1,167,847.8 мянган төгрөгийн авлага, 428,091.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тус тус тайлагнасан байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС, Төсвийн тухай хуулийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг зөрчсөн байна.

#### **1.2 Эрсдэл:**

Авлага, өглөгийг барагдуулаагүй байх, холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

#### **1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж өглөг, авлага үүсгэхгүй ажиллах

#### **1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **2. Балансын данстай холбоотой асуудал**

#### **2.1 Илрүүлэлт:**

Тус байгууллага тайлант хугацаанд 21,033.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй ДГА-2020/03/СТА-ЗГТС

нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

## 2.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх, санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх.

## 2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах

## 2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 3. Зардлын данстай холбоотой асуудал

### 3.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь 6 албан хаагчдад засвартай томилолтын хуудсыг үндэслэн 238.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4. "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн байна.

### 3.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

### 3.3 Өгсөн зөвлөмж:

Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг хийж байх

### 3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,722,053,728.82</b>	<b>6,593,521,856.61</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,103,539,380.42	5,414,306,252.31
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	4,103,539,380.42	5,414,306,252.31
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	4,103,539,380.42	5,414,306,252.31
31211	Төрийн сангийн харилцах	-	4,000,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	4,103,539,380.42	5,410,306,252.31
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,606,593,455.39	1,167,847,826.29
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,518,416,773.32	1,083,818,961.51
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	88,176,682.07	84,028,864.78
3351	Байгууллагаас авах авлага	88,176,682.07	84,028,864.78
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	11,920,893.01	11,367,778.01
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	11,920,893.01	11,367,778.01
35410	Бичиг хэргийн материал	96,000.01	171,100.01
35420	Аж ахуйн материал	6,846,034.00	6,269,000.00
35440	Түлш, шатах тослох материал	280,000.00	
35470	Бусад хангамжийн материал	4,698,859.00	4,927,678.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>494,177,623.51</b>	<b>444,547,197.78</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	494,177,623.51	444,547,197.78
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	468,977,623.51	419,347,197.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	351,060,639.99	351,060,639.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(11,651,677.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,900,000.00	88,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(60,745,833.33)	(72,395,833.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,268,353.00	114,930,485.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(75,386,312.97)	(82,162,392.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,720,811.00	63,463,668.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,840,034.18)	(32,797,692.18)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	25,200,000.00	25,200,000.00
39301	Програм хангамж	5,427,586.00	5,427,586.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,427,586.00)	(5,427,586.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,200,000.00	25,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,216,231,352.33</b>	<b>7,038,069,054.39</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>303,094,003.46</b>	<b>428,091,694.10</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	303,094,003.46	428,091,694.10
<b>413</b>	<b>Өглөг</b>	197,698,063.63	373,539,495.20
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	24,786,360.67	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	172,911,702.96	373,539,495.20
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	105,395,939.83	54,552,198.90
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	105,395,939.83	54,552,198.90
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,913,137,348.87</b>	<b>6,609,977,360.29</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,913,137,348.87	6,609,977,360.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	366,264,211.87	366,264,211.87
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	5,524,227,989.60	6,221,068,001.02
51210	Өмнөх үеийн үр дүн	4,064,291,571.44	5,552,613,769.25
51220	Тайлант үеийн үр дүн	1,459,936,418.16	668,454,231.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,645,147.40	22,645,147.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,216,231,352.33</b>	<b>7,038,069,054.39</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>63,953,018,613.34</b>	<b>53,084,679,743.29</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>34,084,400,303.23</b>	<b>41,766,876,129.66</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	34,084,400,303.23	41,766,876,129.66
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,383,986,839.71	28,178,600,807.77
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,497,138,078.01	2,958,333,283.01
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,539,962,564.07	3,078,762,877.22
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	511,878,745.25	698,518,578.97
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,151,434,076.19	6,852,660,582.69
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>153,892,398.24</b>	<b>257,194,913.63</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	153,892,398.24	<b>257,194,913.63</b>
120002	Хүүгийн орлого	123,038,303.39	206,099,276.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,854,094.85	30,158,430.79
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,710,254.30	21,440,980.79
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,263,951.55	387,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,253,744.00	8,329,850.00
120009	Бусад орлого	15,626,145.00	20,937,206.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>29,714,725,911.87</b>	<b>11,060,608,700.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,346,510.00	3,681,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,700,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,646,510.00	3,681,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	29,246,400,701.87	10,400,500,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,246,400,701.87	10,400,500,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	456,978,700.00	656,427,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	456,978,700.00	656,427,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>62,467,680,359.21</b>	<b>52,416,225,511.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>62,467,680,359.21</b>	<b>52,416,225,511.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	520,864,474.14	626,393,774.45
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	355,707,846.00	420,576,952.00
210101	Үндсэн цалин	298,605,475.00	353,871,122.00
210102	Нэмэгдэл	13,663,500.00	56,243,830.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,336,900.00	10,462,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,101,971.00	53,763,862.27
210201	Тэтгэврийн даатгал	42,727,899.00	35,989,529.40

**Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210202	Тэтгэмжийн даатгал	28,602,055.60	4,446,271.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,533,597.25	3,553,791.30
210204	Ажилгүйдлийн даатгал	2,824,314.12	887,103.73
210205	Эрүүл мэндийн даатгал	705,010.33	8,887,166.43
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,651,326.74	26,486,864.51
210301	Гэрэл, цахилгаан	4,228,594.00	3,913,383.51
210302	Түлш, халаалт	20,066,499.65	21,099,621.00
210303	Цэвэр, бохир ус	1,356,233.09	1,473,860.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,467,545.96	20,105,291.50
210401	Бичиг хэрэг	3,156,727.96	5,053,390.00
210402	Тээвэр, шатахуун	5,368,550.00	8,903,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,259,769.00	3,240,409.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	227,200.00	227,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	455,299.00	2,680,492.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,625,750.00	10,696,866.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	462,000.00	1,830,600.00
210604	Урсгал засвар	4,163,750.00	8,866,266.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,013,000.00	4,661,000.00
210702	Дотоод албан томилолт	3,013,000.00	4,661,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	27,706,056.00	37,743,112.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,905,873.00	22,426,318.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	1,408,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,070,000.00	1,399,573.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,993.00	148,500.00
210807	Газрын төлбөр	729,840.00	304,920.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,105,850.00	4,210,120.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,850,500.00	7,845,681.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	49,965,050.44	52,359,825.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	730,200.00	2,729,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,234,850.44	49,630,425.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	61,946,815,885.07	51,789,831,737.07
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	37,071,165,869.62	42,567,148,181.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	37,044,097,669.62	42,497,175,081.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,100,000.00	12,788,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,968,200.00	57,185,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	24,875,650,015.45	9,222,683,556.07

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,875,650,015.45	9,222,683,556.07
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,485,338,254.13</u></b>	<b><u>668,454,231.77</u></b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-1,988,489.43	
	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-1,988,489.43	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	23,413,346.54	
	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	23,413,346.54	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-25,401,835.97	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,459,936,418.16</u></b>	<b><u>668,454,231.77</u></b>

**4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>63,625,704,136.92</u></b>	<b><u>53,524,262,787.85</u></b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b><u>33,708,696,480.43</u></b>	<b><u>42,160,672,375.54</u></b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	33,708,696,480.43	42,160,672,375.54
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,139,950,322.86	28,440,504,116.92
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,465,816,129.44	2,989,165,514.96
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,513,208,660.11	3,107,190,870.27
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	507,671,652.58	707,438,228.43
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,082,049,715.44	6,916,373,644.96
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>214,545,337.20</u></b>	<b><u>298,981,712.31</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	214,545,337.20	298,981,712.31
120002	Хүүгийн орлого	123,038,303.39	206,099,276.84
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	91,507,033.81	.
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,243,082.26	92,494,835.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,263,951.55	387,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>29,702,462,319.29</u></b>	<b><u>11,064,608,700.00</u></b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,346,510.00	7,681,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,700,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,646,510.00	7,681,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	29,234,137,109.29	10,400,500,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,234,137,109.29	10,400,500,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	456,978,700.00	656,427,700.00

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	456,978,700.00	656,427,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>62,195,626,766.89</u></b>	<b><u>52,213,495,915.96</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>62,195,626,766.89</u></b>	<b><u>52,213,495,915.96</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>443,998,728.44</u></b>	<b><u>592,666,744.39</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	333,146,860.00	442,770,678.90
210101	Үндсэн цалин	273,605,060.00	399,805,878.90
210102	Нэмэгдэл	13,663,500.00	33,170,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,260,800.00	9,794,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,617,500.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,507,400.00	56,356,496.04
210201	Тэтгэврийн даатгал	26,446,253.56	37,725,038.45
210202	Тэтгэмжийн даатгал	3,267,261.98	4,660,682.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,611,439.14	3,725,164.39
210204	Ажилгүйдлийн даатгал	651,872.10	929,882.18
210205	Эрүүл мэндийн даатгал	6,530,573.22	9,315,728.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,651,326.74	26,486,864.51
210301	Гэрэл, цахилгаан	4,228,594.00	3,913,383.51
210302	Түлш, халаалт	20,066,499.65	21,099,621.00
210303	Цэвэр, бохир ус	1,356,233.09	1,473,860.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,002,358.40	19,068,007.50
210401	Бичиг хэрэг	3,128,706.40	5,128,490.00
210402	Тээвэр, шатахуун	5,538,550.00	8,623,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,259,769.00	3,240,409.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	227,200.00	227,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	848,133.00	1,848,108.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,382,150.00	10,696,866.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	336,400.00	1,830,600.00
210604	Урсгал засвар	4,045,750.00	8,866,266.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,013,000.00	4,661,000.00
210702	Дотоод албан томилолт	3,013,000.00	4,661,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	25,565,433.30	29,897,431.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,905,873.00	22,426,318.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	1,408,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,070,000.00	1,399,573.00

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,993.00	148,500.00
210807	Газрын төлбөр	729,840.00	304,920.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,105,850.00	4,210,120.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,709,877.30	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	730,200.00	2,729,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	730,200.00	2,729,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,751,628,038.45</b>	<b>51,620,829,171.57</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	36,875,978,023.00	42,398,145,615.50
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	36,839,005,157.16	42,313,659,056.35
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,100,000.00	12,788,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,904,665.84	14,513,459.15
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,968,200.00	57,185,100.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	24,875,650,015.45	9,222,683,556.07
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,875,650,015.45	9,222,683,556.07
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,430,077,370.03</u></b>	<b><u>1,310,766,871.89</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,700,000.00</b>	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,700,000.00</b>	
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	3,700,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,700,000.00	
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-3,700,000.00</u></b>	
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		≡
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	1,426,377,370.03	1,310,766,871.89
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	2,677,162,010.39	4,103,539,380.42
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	4,103,539,380.42	5,414,306,252.31

**4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87	-	4,008,217,919.57	4,374,482,131.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	56,073,651.87	56,073,651.87
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,264,211.87	-	4,064,291,571.44	4,430,555,783.31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	22,645,147.40	-	22,645,147.40
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,459,936,418.16	1,459,936,418.16
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	5,524,227,989.60	5,913,137,348.87
D01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	5,524,227,989.60	5,913,137,348.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	28,385,779.65	28,385,779.65
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	5,552,613,769.25	5,941,523,128.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	22,645,147.40	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	668,454,231.77	668,454,231.77
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	6,221,068,001.02	6,609,977,360.29

**4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>36,959,258,200.00</b>	<b>37,297,715,698.30</b>	<b>43,136,518,100.00</b>	<b>42,972,617,900.74</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>36,959,258,200.00</b>	<b>37,297,715,698.30</b>	<b>43,136,518,100.00</b>	<b>42,972,617,900.74</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	438,415,000.00	432,742,341.14	597,002,100.00	590,841,744.39
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	328,262,600.00	328,262,600.00	442,775,900.00	442,770,678.90
210101	Үндсэн цалин	268,720,800.00	268,720,800.00	399,811,100.00	399,805,878.90
210102	Нэмэгдэл	13,663,500.00	13,663,500.00	33,170,400.00	33,170,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,260,800.00	10,260,800.00	9,794,400.00	9,794,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,617,500.00	35,617,500.00	-	-
210201	Тэтгэврийн даатгал	26,338,300.00	26,338,300.00	40,202,400.00	37,725,038.45
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	227,200.00	227,200.00	227,200.00	227,200.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,388,000.00	4,382,150.00	10,703,000.00	10,696,866.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	336,600.00	336,400.00	1,836,600.00	1,830,600.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,520,843,200.00</b>	<b>36,864,973,357.16</b>	<b>42,539,516,000.00</b>	<b>42,381,776,156.35</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>36,520,843,200.00</b>	<b>36,864,973,357.16</b>	<b>42,539,516,000.00</b>	<b>42,381,776,156.35</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-	10,945,000.00	10,932,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	28,830,043.36	-	39,641,769.31
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	<b>2,677,162,010.39</b>	-	4,103,539,380.42
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	<b>4,103,539,380.42</b>	-	5,414,306,252.31

#### 4.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /НЭМЭЛТ ДАНС/ /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>3,681,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>3,681,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		1,825,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		1,100,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,100,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		325,000.00
210702	Дотоод албан томилолт		325,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		400,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	1,856,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		1,856,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,856,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>3,681,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>3,681,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,681,000.00